

Independent Director Report of Xacbank – Q3 2022

I, **Niraj Vedwa**, hereby report on the delivery and performance of my duties as Independent Director of the Board of Directors for Xacbank (XB) during the 3rd Quarter of 2022 (the Reporting Period). I was appointed Independent Non Executive Director of Xacbank in June 2019 and was re-elected for 2 years in April 2021. As Independent Director of Xacbank, my role and duties are guided by the following laws and regulations:

- the Company Law of Mongolia,
- the Banking Law of Mongolia,
- the "Corporate Governance Principles of the Bank" issued by the BoM,
- the "Procedure on Independent director of a bank" issued by Financial Stability Counsel,
- the Charter of Xacbank
- and bylaw regulation documents.

During the Reporting period:

- I. I have attended in person at ICC Tower, UB, Q3 2022 Board meetings of the Board of Directors held during the Reporting Period and oversaw the Bank's activities. Clarified issues and approved agenda points in the BRMC /BAC and participated in GNC meetings with the management. Also discussed in detail the current IT implementations of Core Banking & Digital Banking and the plan going forward to Digitize the Front / Middle and Backoffice
- II. Met with HOD's of Retail Banking / Corporate Banking / IT and the COO / CFO along with other Board Directors who were present in UB.
- III. Also visited Ecobranch (Ger District) / City branch and Narantuul branch to see branch Operations and Customer initiatives.
- IV. Had networking dinner with Management team along with other Board Directors present.

Sept 21st 2022 - Attended XB Board Meeting where the agenda items included Updates on Previous Board decisions and recommendations / Reports of GNC (Governance, Nomination and Compensation Committee) ,Risk Management Committee (BRMC) , Audit Committee (BAC) / Group Management update including Financials and KPIs / Updates on Corporate Re-structuring and next steps including EGM which has been called for on 21st Oct./ IT Updates / Update and impact due to the Russia Ukraine tensions. Approved the Board points during Voting process in GNC / BRMC / BAC meetings of Board.

20th Sept 2022 – Attended BRMC (Bank Risk Management Committee) / BAC (Bank Audit Committee) and GNC (Governance & Compensation Committee) meetings

BRMC – As member of BRMC, I attended the meeting with an agenda covering approval of agenda and minutes of previous BRMC meeting / Macroeconomic Update as off August 2022 / XB risk report as off August 2022 / Update of Sanctions on account of Russia Ukraine tensions / Compliance Update / Amendment to BRMC Charter / Approval of Related Party Transactions. All BRMC Directors were present in person or online on Zoom.

BAC – As member of XB Audit Committee (BAC), I attended the meeting where the agenda covered various Audit Reports – Reports on Customer Documentation Management / Monthly Monitoring Report Q3 / IT – SWIFT Messaging / Related Party Quarterly Reporting / XB Half Year Review. There were suggestions given by me to automate the Document Management process thru Digital means and effective use of technology.

GNC – While I am not a member of GNC, I participated in the GNC meeting that covered – Update on selection process for 2 vacant Independent Directors of XB / Interim appointment of Mr Erik Versavel as Independent Non Executive Director basis BOM approval / Update on BOM Corporate Governance Assessment Annual Report / Board and Director's Evaluation Summary Results basis compliance requirement from BOM and Legal / FRC Corporate Governance Codex / Amendment of Board rules on determination base of Director's compensation payable / Amendment to XB Charter and amendments to XB charters (Clauses 8.5.1 & 7.8)

As Independent Director, I am of the view that the Bank has been professional & prudent with Strategic Planning, Risk management, Corporate Governance, Regulatory Compliance, Digital Transformation, KPI Execution and monitoring. Bank's key metrics and ratios are well within budgets and policy guidelines. Bank is focused on giving the highest priority on 100% compliance to BOM Guidelines and delivering highest customer satisfaction and shareholder value.


I have confirmed to BOM and Company law guidelines.

As per Article 79.3 of the Company Law, an independent member of the Board of Directors shall have the following additional obligations in addition to the rights and obligations of the other members

- 79.3.1. monitor whether the activities, policies and decision of the Board of

Directors and of the executive body negatively affects the interests of the company, whether the activities are in compliance with the laws, rules and procedures, prevent from violations or conflicts, demand from the relevant person to eliminate any violations, if such demand is not complied with, to submit such matter for consideration by the Board of Directors and consequently, to submit the demand to convene a shareholders meeting;

- 79.3.2. to guide the executive body in respect of maintaining the transparency and accessibility of the company's activities, monitor and make demands in respect thereof;
- 79.3.3. to take part in the shareholder's meetings in person, and to inform of any different views taken in respect of the decision rendered by the Board of Directors, respond to questions by the shareholders and to make clarifications.
- During the reporting period in accordance with Article 79.3, item 79.3.3.1 as Independent Director, My every vote was made with consideration of all stakeholders (the Bank, shareholders, employees and customers), regulatory requirements and in line with Bank's internal rules and procedures



Niraj Vedwa

Independent Director on Board - Xacbank

ХасБанкны Хараат бус гишүүний тайлан – 2022 оны 3 дугаар улирал

Нираж Ведва миний бие ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр ажилласан 2022 оны 3 дугаар улирал (тайлант хугацаа)-ын хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа үүгээр хүргүүлж байна. Миний бие 2019 оны 6 дугаар сард ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдсон бөгөөд 2021 оны 4 дүгээр сард 2 жилийн хугацаатайгаар улиран томилогдсон. ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд дараах хууль тогтоомжийг удирдлага болгож ажиллаж байна:

- Компанийн тухай хууль
- Банкны тухай хууль
- Монголбанкны “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”
- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн “Банкны хараат бус гишүүний ажиллах журам”
- ХасБанкны дүрэм
- Холбогдох бусад хууль тогтоомж, баримт бичиг

Тайлант хугацаанд:

- I. Тайлант хугацаанд Улаанбаатар хот, Ай Си Си тауэрт болсон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 3 дугаар улирлын хуралд биечлэн оролцож, банкны үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан. Эрсдэлийн удирдлагын хороо/Аудитын хорооны хурлуудад асуудлыг тодруулах, хэлэлцсэн асуудлыг батлах байдлаар мөн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны хуралд удирдлагын багийн хамт тус тус оролцсон. Түүнчлэн Банкны үндсэн систем болон Цахим банкны мэдээллийн технологийн одоогийн шилжилт, хяналтын 1, 2 болон 3 дугаар бүсийг цахимжуулахад чиглэсэн төлөвлөгөөний талаар нарийвчлан хэлэлцсэн.
- II. Улаанбаатар хотод биечлэн ирсэн ТУЗ-ийн бусад гишүүдтэй хамт Иргэдийн банк / Байгууллагын банк / Мэдээллийн технологийн газар, хэлтсийн захирлуудтай болон Үйл ажиллагаа хариуцсан захирал / Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Санхүү хариуцсан захиралтай уулзсан.
- III. Салбарын үйл ажиллагаа болон харилцагчийн санал хүсэлттэй танилцах зорилгоор эко салбар (гэр хорооллын) / хотын салбар болон Нарантуул салбараар зочилсон.
- IV. Биечлэн ирсэн ТУЗ-ийн бусад гишүүдтэй хамт Удирдлагын багтай оройн хоол идсэн.

2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр – Өмнөх ТУЗ-ийн шийдвэр, зөвлөмж / Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хорооны тайлангууд / Санхүүгийн болон гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт зэрэг Нэгдэлийн удирдлагын мэдээлэл / Компанийг өөрчлөн байгуулах болон 10 дугаар сарын 21-ний өдөр зарлагдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг оролцуулсан дараагийн алхмууд талаарх мэдээлэл / Мэдээллийн технологийн мэдээлэл / ОХУ Украйнаас шалтгаалсан шинэ мэдээлэл, нөлөөллийн талаарх шинэ мэдээллүүдийг багтаасан хэлэлцэх асуудал бүхий ХасБанкны ТУЗ-ийн хуралд оролцсон. ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо / Эрсдэлийн удирдлагын хороо / Аудитын хорооны хуралд санал өгөх үеэр ТУЗ-ийн саналыг баталсан.

2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр – Эрсдэлийн удирдлагын хороо / Аудитын хороо болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны хуралд оролцсон.

Эрсдэлийн удирдлагын хороо – Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүний хувьд миний бие өмнөх Эрсдэлийн удирдлагын хорооны хурлын хэлэлцэх асуудал, тэмдэглэл / 2022 оны 8 дугаар сарын байдлаарх Макро эдийн засгийн мэдээлэл / 2022 оны 8 дугаар сарын байдлаарх ХасБанкны эрсдэлийн тайлан / ОХУ Украинийн хурцадмал байдлаас үүдэлтэй хориг арга хэмжээний мэдээлэл / Хянан нийцүүлэлтийн талаарх мэдээлэл / Эрсдэлийн удирдлагын хорооны Дүрмийн өөрчлөлт / Холбогдох этгээдийн гүйлгээг батлах асуудлыг хэлэлцэх хуралд оролцсон. Эрсдэлийн удирдлагын хорооны бүх гишүүд биечлэн болон цахимаар оролцсон.

Аудитын хороо – ХасБанкны Аудитын хорооны гишүүний хувьд миний бие олон төрлийн Аудитын тайлангууд – Харилцагчийн хувийн хэрэг удирдлагын тайлангууд / Сар бүрийн хяналтын тайлан 3 дугаар улирал / Мэдээллийн технологи – Свифт мессеж / Холбогдох этгээдийн улирлын тайлан / ХасБанкны хагас жилийн тайлангийн талаар хэлэлцсэн хуралд оролцсон. Миний зүгээс цахим хэрэгсэл болон технологийг үр дүнтэй ашиглах замаар баримт бичгийн удирдлагыг цахимжуулах саналыг өгсөн.

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо – Миний бие Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүн биш боловч ХасБанкны Хараат бус гишүүний 2 сул орон тооны сонгон шалгаруулалтын талаарх мэдээлэл / Монголбанкнаас зөвшөөрсөний дагуу Хараат бус гишүүнээр Эрик Версавелийг түр хугацаанд томилсон асуудал / Монголбанкны Компанийн засаглалын үнэлгээний жилийн тайлангийн мэдээлэл / Монголбанкны болон хууль зүйн шаардлагад нийцүүлсэн ТУЗ болон ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээний товч дүгнэлт / Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекс / ТУЗ-ийн гишүүдэд олгогдох цалин

урамшууллыг тодорхойлохтой холбоотой ТУЗ-ийн дүрмийн өөрчлөлт /ХасБанкны Дүрмийн нэмэлт өөрчлөлтүүд (8.5.1 дэх заалт болон 7.8 дахь хэсэг)-ийн талаар хэлэлцсэн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны хуралд оролцсон.

Хараат бус гишүүний хувьд миний бие Банкны Стратегийн төлөвлөгөө, эрсдэлийн удирдлага, компанийн засаглал, хянан нийцүүлэлт, цахим шилжилт, гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийн хэрэгжилт ба хяналтыг мэргэжлийн бөгөөд оновчтой хэрэгжүүлсэн гэж үзэж байна. Банкны түлхүүр үзүүлэлтүүд болон харьцаа нь төсөвтөө багтаж, бодлогод бүрэн нийцсэн. Банк нь Монголбанкны удирдамжид 100% нийцүүлэх болон харилцагчийн сэтгэл ханамж, хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг хамгийн өндөр байлгахад өндөр ач холбогдол өгөхөд төвлөрч байгаа болно.

Миний хувьд Монголбанкны журмын болон Компанийн тухай хуулийн заалтуудыг дагаж мөрдсөн.

Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэгт “Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь бусад гишүүний адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүргийг хүлээнэ:

- 79.3.1. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;
- 79.3.2. компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
- 79.3.3. хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.
- Тайлангийн хугацаанд Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3.1 дэх заалтад заасны дагуу хараат бус гишүүний хувьд миний өгсөн санал бүр оролцогч талууд (Банк, хувьцаа эзэмшигчид, ажилтнууд болон харилцагчид)-ыг харгалзан үзсэн, хууль тогтоомжийн шаардлага, Банкны дотоод дүрэм, журамд нийцсэн байсан.

Нираж Ведва

ТУЗ-ийн хараат бус гишүүн - ХасБанк